

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/085 /НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн захирал: М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaataudit.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/312
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 708,480.8 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тайлант онд 13,431,979.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 12,680,053.2 мянган төгрөгийг зарцуулж, 751,926.1 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18 дугаар тогтоолоор Баянгол тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, 21 дүгээр тогтоолоор

Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулахаар орон тоо, бүтцийг тус тус шинэчлэн баталж тус байгууллагыг 2 хуваасан байна. Төрийн аудитын байгууллагад 2024 оны санхүүгийн тайлан, холбогдох баримт, материалыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй нь аудит хийх цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 95.5 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023-12-31	2024-12-31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	226,085,451.31	488,760,986.91
1.1.2	Дансны авлага	32,053,303.66	3,280,838.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	17,642,013.52
1.1.4	Бусад авлага	-	7,189,084.00
1.1.6	Бараа материал	428,414,166.60	1,227,521,400.49
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	556,416.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	687,109,337.57	1,744,394,322.92
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,784,771,869.36	4,609,748,187.59
1.2.2	Биет бус хөрөнгө	141,550,542.75	138,587,042.79
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,926,322,412.11	4,748,335,230.38
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,613,431,749.68	6,492,729,553.30
2.1.1.1	Дансны өглөг	43,773,325.00	2,500,364.99
2.1.1.2	Цалингийн өглөг	6,209,737.69	342,034.69
2.1.1.3	Татварын өр	63,217,927.86	126,360,161.72
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,591,645,724.51	4,703,015,812.50
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,704,846,715.06	4,832,218,373.90
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,704,846,715.06	4,832,218,373.90
2.3	Эздийн өмч	611,349,900.00	611,349,900.00
2.3.1	Өмч: - төрийн	611,349,900.00	611,349,900.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22,187,041.54	22,187,041.54
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	132,500,000.00	132,500,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	333,879,932.30	142,548,093.08
2.3.10	Тайлант үеийн ашиг (алдагдал)	(191,331,839.22)	751,926,144.79
2.3.11	Эздийн өмчийн дүн	908,585,034.62	1,660,511,179.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,613,431,749.68	6,492,729,553.31

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2023-12-31	2024-12-31
Борлуулалтын орлого (цэвэр)	7,875,364,548.13	12,004,498,934.00
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	7,875,364,548.13	12,004,498,934.00
Хүүний орлого	-	5,485,823.49
Бусад орлого	589,430,310.30	1,421,994,553.08
Борлуулалт, маркетингийн зардал	3,773,504,433.39	3,933,428,243.04
Ерөнхий ба удирдлагын зардал	4,882,210,638.00	8,632,389,240.36
Санхүүгийн зардал	411,626.26	-
Бусад зардал	-	25,807,765.55
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(191,331,839.22)	840,354,061.62
Орлогын татварын зардал	-	88,427,916.83
Татварын дараах ашиг (алдагдал)	(191,331,839.22)	751,926,144.79
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(191,331,839.22)	751,926,144.79
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	(191,331,839.22)	751,926,144.79

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022-12-31-ний үлдэгдэл	611,349,900.00	22,187,041.54	132,500,000.00	333,879,932.30	16,282,258.40
3	Залруулсан үлдэгдэл	611,349,900.00	22,187,041.54	132,500,000.00	333,879,932.30	1,099,916,873.84
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(191,331,839.22)	(191,331,839.22)
1	2023-12-31-ний үлдэгдэл	611,349,900.00	22,187,041.54	132,500,000.00	142,548,093.08	908,585,034.62
3	Залруулсан үлдэгдэл	611,349,900.00	22,187,041.54	132,500,000.00	142,548,093.08	908,585,034.62
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	751,926,144.79	751,926,144.79
9	2024-12-31-ний үлдэгдэл	611,349,900.00	22,187,041.54	132,500,000.00	894,474,237.87	1,660,511,179.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2023	12/31/2024
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,875,364,500.00	12,014,547,818.49
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,860,985,800.00	12,004,498,900.00
	Бусад мөнгөн орлого	14,378,700.00	10,048,918.49
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,919,500,500.00	11,671,375,832.89
	Ажиллагчдад төлсөн	3,398,258,800.00	7,385,988,972.06
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,033,855,200.00	1,004,426,936.55
	Бараа материал худалдан авахад төлсөн	531,896,900.00	588,119,664.00
	Ашиглалтын зардалд төлсөн	88,070,000.00	78,074,963.57
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,437,582,700.00	1,832,988,813.99
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	241,924,400.00	630,386,522.34
	Даатгалын төлбөрт төлсөн	57,381,700.00	46,880,685.00
	Бусад мөнгөн зарлага	130,530,800.00	104,509,275.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(44,136,000.00)	343,171,985.60
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	52,284,000.00	80,496,450.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	52,284,000.00	80,496,450.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(52,284,000.00)	(80,496,450.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
	Валютын ханшийн зөрүү	-	(0.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(96,420,000.00)	262,675,535.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	322,505,451.31	226,085,451.31
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,085,451.31	488,760,986.91

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
Хог тээвэр	6,459,998.7	9,069,206.5	(2,609,207.8)	140.4
Зам талбайн цэвэрлэгээ	3,039,999.4	2,212,463.2	827,536.2	72.8
НЗДТГ НЭЗТ цэвэрлэгээний орлого	-	722,829.3	(722,829.3)	
Бусад орлого	-	1,427,480.4	(1,427,480.4)	

**Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

Нийт орлого	9,499,998.0	13,431,979.3	(3,931,981.3)	141.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,618,402.0	7,418,245.9	(1,799,843.9)	132.0
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	814,668.3	989,481.7	(174,813.4)	121.5
Байр ашиглалттай холбоотой	84,300.0	53,000.0	31,300.0	62.9
Байрны түрээс	37,800.0	58,941.9	(21,141.9)	155.9
Түлш шатахуун	1,469,631.1	1,485,641.5	(16,010.4)	101.1
Тос тослох материал	82,775.0	-	82,775.0	-
Бичиг хэрэг	19,877.4	12,310.7	7,566.7	61.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,000.0	9,353.0	(353.0)	103.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	128,696.5	58,694.4	70,002.1	45.6
Багаж, техник, хэрэгсэл / Сэлбэг/	127,882.0	412,117.7	(284,235.7)	322.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,740.6	162,122.3	(124,381.7)	429.6
Зар сурталчилгаа /Ном, хэвлэл /	9,000.0	26.1	8,973.9	0.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,000.0	420.0	24,580.0	1.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,587.5	-	30,587.5	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,650.0	166,961.4	7,688.6	95.6
Хөрөнгө худалдан авах Тавилга, эд хогшил	20,000.0	-	20,000.0	-
Урсгал засвар	540,127.6	743,407.3	(203,279.7)	137.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,800.0	40,267.2	(467.2)	101.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000.0	-	8,000.0	-
Даатгалын үйлчилгээ	68,860.0	46,880.7	21,979.3	68.1
Тээврийн хэрэгслийн татвар	12,500.0	-	12,500.0	-
Тээврийн хэрэгслийн оношлогоо /зөвшөөрөл/	12,500.0	-	12,500.0	-
Газрын төлбөр	7,700.0	-	7,700.0	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000.0	-	1,000.0	-
Элэгдлийн зардал	-	772,745.4	(772,745.4)	-
Улсын мэдээлэлийн маягт хэвлэх бэлтгэх	1,000.0	-	1,000.0	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,000.0	38,451.4	1,548.6	96.1
Сургалтын зардал	40,000.0	41,055.0	(1,055.0)	102.6
Бараа үйлчилгээний бусад зардал	38,500.0	81,501.6	(43,001.6)	211.7
Нийт зардал	9,499,998.0	12,591,625.2	(3,091,627.2)	132.5
Татварын өмнөх ашиг (+), алдагдал (-)	-	840,354.1	(840,354.1)	-
Орлогын татварын зардал	-	88,427.9	(88,427.9)	-
Цэвэр ашиг (+), алдагдал (-)	-	751,926.1	(751,926.1)	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 125,712.1 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Аудитаар 708,480.8 нийт мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 4,198.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 679,613.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 24,669.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тээврийн зардлыг гадаад албан томилолтын зардлаар тайлагнасныг залруулав.	1	5,950.0			1	5,950.0	1	5,950.0				
Шүүхийн шийдвэрээр цалингаас хийх суутгалыг цалингийн зардлаар тайлагнасан	1	12,502.9			1	12,502.9	1	12,502.9				
Цалинг буруу тооцоолж дутуу олгосон.	1	314.3			1	314.3	1	314.3				
Байгууллагад өгөх өр төлбөрийг илүү илэрхийлсэн.	1	4,017.1			1	4,017.1	1	4,017.1				
Буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн актыг цалингийн зардлаар бүртгэсэн.	1	1,094.2			1	1,094.2	1	1,094.2				
ААНОАТ-ын өглөгийг үйлчилгээний хураамжийн зардлаар тайлагнасан	1	13,405.7			1	13,405.7	1	13,405.7				
Тайлант үеийн татварын зардлыг залруулан бүртгэв.	1	88,427.9	1	88,427.9			1	88,427.9				
Дүн	7	125,712.1	1	88,427.9	6	37,284.2	7	125,712.1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалинг алдаатай тооцож илүү олгосон.	1	1,649.8	1	1,649.8								
Нийгмийн даатгалын тайланг зөрүү тайлагнаснаас алданга үүсч байгууллагаас төлсөн	1	453.2	1	453.2								
Торгуулийг байгууллагаас төлж, буруутай этгээдээс суутган тооцоогүй.	1	2,095.0	1	2,095.0								
Үндсэн хөрөнгийн бүртгэлд 6 ширхэг тээврийн хэрэгсэл ашиглагдахгүй байна. /Хүлээн авах үед мотор нь хөлдсөн тайлбартай/	1	418,600.0			1	418,600.0						
Ажил үйлчилгээний худалдан авалтад босго үнийг баримтлаагүй.	1	213,400.7			1	213,400.7						
Хойшлогдсон татварын өр төлбөрийг бүртгээгүй байна.	1	2,218.7					1	2,218.7				
НД-ийн тайланд цалингийн дүнг буруу тайлагнаж шимтгэлийн зөрүү үүсгэсэн.	1	6,640.1					1	6,640.1				
Татварын цахим системд борлуулалтыг үнэн зөв бүртгэж шивээгүйгээс татварын тайлан буруу алдаатай тайлагнасан.НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй.	1	47,612.4			1	47,612.4						
Үндсэн хөрөнгийн тооллогоор гражийн удирдлагатай хаалганы тоо хэмжээг буруу бүртгэсэн байна.	1	15,810.9					1	15,810.9				
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй.	1				1							
Дүн	8	708,480.8	3	4,198.0	2	679,613.1	3	24,669.7				

Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

АДБОУС 4000. 16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулсан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээллийг хугацаа хоцроож, 15 мэдээллийг мэдээлээгүй.	1				1			
Дүн	1				1			

5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТБОНӨҮГ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		